



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 03 өдөр

Дугаар A/91

Бор-Өндөр сум

**Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
хаврын дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/165 дугаар тушаал, Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2024 оны А/31 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтын арга хэмжээг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнээр баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Б.Болормаа

Нарийн бичгийн дарга

Р.Цэндсүрэн

Гишүүд

И.Энхтуяа

У.Пүрэвсүрэн

С.Байгалмаа

Ч.Саруулмөнх

Б.Мөнх-Оргил

Н.Отгонбилэг

Ц.Бат-Эрдэнэ

Ц.Төртүвшин

Мал эмнэлгийн тасгийн дарга

Тархвар зүйч

1 дүгээр багийн Засаг дарга

2 дугаар багийн Засаг дарга

3 дугаар багийн Засаг дарга

4 дүгээр багийн Засаг дарга

5 дугаар багийн Засаг дарга

6 дугаар багийн Засаг дарга

“Ноён Зүлэгт” ХХК МЭҮН-ийн захирал

“Эн Тэ Чи” ХХК МЭҮН-ийн захирал

2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтын арга хэмжээг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд сумын хэмжээнд бүх үхрийг хамруулан 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 10 хоногт багтаан шуурхай зохион байгуулсугай.

3. Малчдад урьдчилан мэдэгдэх, тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэх, товолсон цагт үхэр сүргээ бүрэн байлгаж хамруулахыг Багийн Засаг дарга нарт, урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч Б.Болормаа-д даалгасугай.

4. Вакцинжуулалтад малаа бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчин, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Б.Болормаа)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Ууганжаргал)-д, гүйцэтгэлийг вакцинжуулалт дууссанаас хойш 7 хоногийн дотор танилцуулж, тарилгын материалыг дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Б.Болормаа)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ